

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 06 дугаар сарын 29

Дугаар 48

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 2022 оны газар зохион  
байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/588 тоот албан бичгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн долдугаар хуралдааны 48 дугаар тогтоолын хавсралт

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2022 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД**

№	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Төлөвлөгөөнд тусгах үндэслэл болон санал ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
0	1	2	3	4
<b>1.1. Хууль эрх зүйн чиглэлээр хийх ажлууд</b>				
1.	Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хууль, Кадастрын тухай хууль зэрэг 5 хуульд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох талаар газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд байгууллагатай нягт хамтран ажиллаж, зарим эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал өгч оролцоно.	НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ, ДИТХ	I-IV улиралд	Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, Нийслэл, дүүргийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, ДИТХ-ын Төлөөлөгч, дүүргийн бусад байгууллага болон иргэдийн санал, хүсэлтийн дагуу тусгасан.
2.	ДИТХ, Засаг даргаас гарах газар холбоотой тогтоол шийдвэрүүдэд санал өгч газрын тухай хуулинд нийцүүлэх талаар хамтран ажиллана. Дүүргийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж дүүргийн удирдлагуудыг мэргэжлийн мэдээллээр ханган төслийг танилцуулах, батлуулах	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэл, дүүргийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, ДИТХ-ын Төлөөлөгч, дүүргийн бусад байгууллага болон иргэдийн санал, хүсэлтийн дагуу тусгасан.
3.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал өгч оролцоно.	НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ, УСУГ	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан зарим хил нь олон жил суурьшин амьдарч буй иргэдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газартай давхацсан, зарим хэсэгт тогтоолд авах шаардлагагүй газруудыг хамааруулсан зэргээс шалтгаалан тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учирч, Монгол Улсын Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дэх заалтууд бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа тул тогтоолыг өөрчлөх шаардлагатай болсон;

4.	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоол;
5.	Тусгай хамгаалалттай газар нутаг /Богдхан уул/, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх асуудлын хүрээнд холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, санал хүргүүлэх	НГЗБА, НХБХГ, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 6.1 дэх заалт;
6.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг Улаанбаатар хотын эдэлбэр газар, түүнтэй холбоотой дүрэм, журмын төсөл шинэчлэн боловсруулалтад санал өгч оролцох	НГЗБА, НХБХГ, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль

### 1.2 Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил

7.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг хангах	НГЗБА, НХБХГ, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт;
8.	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах	НЗДТГ, ЗАА, НГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дахь заалт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт;
9.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Газрын бирж”-ийн цахим систем / <a href="http://www.mle.mn/">www.mle.mn/</a> -ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 23.2.7 дахь заалт “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах”; Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 152 дугаар тогтоол;
10.	Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг зохион байгуулах	НХБХГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.3.2 дахь заалт;
11.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, системийн хөгжүүлэлтэд санал өгч хамтран ажиллах	НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дахь заалт

### 1.3 Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил

12.	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА, НХБХГ	I-IV улиралд	Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль
13.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	НГЗБА, НХБХГ, ХСОАБХЗГ ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	“Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, ЗТБХБСайдын 2010 оны 418 дугаар тушаал;
14.	Орон сууцны хороолол дундах автомашины гараашуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэн нийтийн эдэлбэр газраар бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	НГЗБА, НХБХГ, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4 дэх заалт;
15.	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийг нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжаар цуцлах, тухайн байршилд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тохижилт, ногоон байгууламж, биеийн тамирын талбайг байгуулах ажлыг зохион байгуулах	УБЗАА, НХБХГ, НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 61.1 дэх заалт “Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно”;
16.	Налайх дүүрэг, Баянзүрх дүүргийн хилийн цэсийн маргааныг холбогдох дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	НИТХ, НЗДТГ, НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, УИХ-ын 1996 оны 24 дүгээр тогтоол;
17.	Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг түүний хамгаалалтын бүсийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, хяналт тавих	НИТХ, НГЗБА, ДИТХ	I-IV улиралд	Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоол;
18.	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж, төрийн мэдэлд шилжсэн газруудыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн нээлттэй дуудлага худалдааны зарчмаар газар эзэмших, ашиглах эрх олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалт “Энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ”;
19.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Шархад дэд төвүүдийн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, НХБХГ, АХБ	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.2.2 дахь заалт;
20.	Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах	НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.7 дахь заалт “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ”;

21.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах	НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.6 дахь заалт “Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна”;
22.	Иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй илүү талбайн нь бусдын газар эзэмшилтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөргүй, нийслэлийн газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны төсөл, газар ашиглалтын бүсчлэлтэй уялдаж байгаа тохиолдолд ашиглаж буй илүү талбайн хэмжээг нэмж эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар шийдвэрлэх, болон газрын давхардлыг арилгах ажлыг зохион байгуулах.	ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичигт тусгагдсан газар ашиглалтын бүсчлэлтэй уялдуулж иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэх;
23.	Хувийн хэвшлийн эзэмшилд байгаа газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болох нөхцөл бүрдсэн газруудад холбогдох арга хэмжээ авч, газрыг дахин зохион байгуулалтад оруулах асуудлыг шийдвэрлэх.	ДЗДТГ, ДГЗБА,	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.1 дэх заалт;
24.	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 56.5 дэх заалт “Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна”;
<b>1.4 Газар өмчлөлийн чиглэлээр хийх ажлууд</b>				
25.	Хуучин суурьшил бүхий газарт олон жил амьдарсан, газраа эзэмшиж, өмчилж аваагүй иргэдэд Газрын тухай хууль, МУ-ын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу холбогдох материалыг бүрдүүлж гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах.	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль болон иргэдийн хүсэлтийг үндэслэн тусгалаа.
26.	Баянзүрх дүүргийн ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол;

27.	Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол
<b>1.5 Газрын кадастрын чиглэлээр хийх ажлууд</b>				
28.	Дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, олон нийтийн барилга байгууламж орчмын нийтийн эзэмшлийн зам талбай, машины зогсоол, явган хүний зам, цэцэрлэгжилтийн талбай, авто болон явган зорчигчийн орц гарц, СӨХ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдэлбэр газар, авто замын улаан шугам, инженерийн байгууламж, шугам сүлжээ, ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон дүүргийн Засаг даргын захирамжийг судалж, холбогдох арга хэмжээг үе шаттай авах.	НГЗБА, ДГЗБА,	I-IV улиралд	Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх
29.	Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацааг сунгах, газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох асуудлуудыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх	НГЗБА, ДГЗБА,	I-IV улиралд	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/784 дүгээр захирамж
30.	Газрын нэгдсэн мэдээллийн сан дахь кадастрын зургийн мэдээллийг хянан шалгаж, бодит газраасаа зөрүүтэй бүртгэгдсэн нэгж талбаруудын судалгааг боловсруулж, зөрчил арилгах ажлыг зохион байгуулах.	НГЗБА, ДГЗБА,	I-IV улиралд	Газрын тухай хууль, Газрын кадастрын тухай хуулийг хэрэгжүүлэх
31.	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;
<b>1.6 Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил</b>				
32.	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;
33.	Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх.	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоол;
<b>1.7 Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийх ажлууд</b>				

34.	Нийслэлийн төсвийг бүрдүүлэхэд газрын төлбөрөөс оруулах орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллаж, шинээр тогтоосон үнэлгээний бүсчлэлийн дагуу шаардагдах гэрээнүүдийг шинэчлэх, шинээр байгуулсан гэрээг бүртгэн тайланд тусгах, дүгнэх болон нийтийн эзэмшлийн газарт байрлан үйл ажиллагаа явуулж байгаа газруудаас төлбөр авах, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг тухай бүр дүгнэн дутуу төлөлт, хүү, торгууль, алданги тооцох зэргээр төлбөрийн баазыг нэмэгдүүлж ажиллах.	НГЗБА, ДГЗБА,	I-IV улиралд	“Газрын тухай” хууль болон “Газрын төлбөрийн тухай” хуулийг хэрэгжүүлэх
35.	Нийслэлийн газрын үнэлгээг бодитой болгох зорилгоор зах зээлийн үнийн мэдээллийг дүүрэг тус бүрээр нэгтгэн цуглуулах, бүртгэл, мэдээллийн сан бий болгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА,	I-IV улиралд	“Газрын тухай” хуулийг хэрэгжүүлэх
36.	Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ноогдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол
<b>1.8 Газрын маргаан, зөрчил арилгах, газар чөлөөлөх талаар</b>				
37.	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан объектууд, эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн нэмж ашигласан хашаа, хайс, байгууламж, объект зэргийг нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөх чиг үүрэг бүхий “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулах	НМХГ, ЗАА, НГЗБА, ДГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	2022 оны “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

38.	Улс, нийслэл, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжаар хийгдэх улсын болон орон нутгийн чанартай авто зам, инженерийн шугам сүлжээний трасст орсон иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	ДЗДТГ, ДГЗБА,	I-IV улиралд	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4 дэх заалт
39.	Улс нийслэлийн төсөвт хөрөнгө тусгагдсан сургууль, цэцэрлэгийн барилгын газарт орсон, мөн орон нутгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх зэрэг байршилд иргэн, хуулийн этгээдийн газар чөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх.	ДЗДТГ, ДГЗБА,	I-IV улиралд	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1 дэх заалт
40.	Гэр хорооллын гудамж талбайд зөвшөөрөлгүй хашаа барих, сунгах орц гарцыг хаасан, багасгасан зэрэг зөрчил гаргасан газруудыг хууль тогтоомжийн дагуу шаардах хуудас, мэдэгдэл өгч чөлөөлөх ажлыг зохион байгуулж, зөрчлийг тухай бүр арилгаж “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ”-нд хамруулж ажиллах.	ДЗДТГ, ДГЗБА,	I-IV улиралд	2021 оны “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай



## ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох								
д/д	Дүүрэг	Хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Иргэдийн тоо	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
0	1	2	3	4	5	6	7	8
1.	Баянзүрх	2	Их Дарь-эх	Гэр бүлийн хэрэгцээ	0.75	12	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
2.		4	Цэргийн хотхон гудамж		1.15	30		
3.		5	Монелийн гудамж		2.45	68		
4.		8	Улаанхуаран, Эрдэнэтолгой, Холбоо толгойн гудамж		0.5	9		
5.		9	Ээж хайрхан, Цагаан давааны ам, Шар хад, Тоосгоны ар, Үнэгтийн ам, Давсны булаг		13.1	231		
6.		10	Витсамо, Улаанхуаран, Амгалан, Төмөр зам, Хангамжийн гудамж		2.2	50		
7.		11	Товчоо, Туул, Эмийн ургамал, Хонхор, Усан сан, Сүүл даваа, Нам даваа, Хонхор нуур, Дэнж, Баянбулаг, Баянзүрх, Ургах наран, Булгачин, Хөлийн гол		69.86	1155		
8.		12	Сармисны хонхор, Жанжин, Чулуут, Төмөр зам		1.36	27		
9.		13	Дүүрэг		0.06	2		
10.		14	Консул		0	0		
11.		16	72 хотхон		0.07	2		
12.		17	Ногоочин, Эрдэнэтолгой, Эмнэлэг		0.55	21		
13.		19	Цайз, Жаргалант, Дэнж		1.55	28		
14.		20	Булагийн ам, Баяндөхөм, Улиастай ам, Гүнжийн хоолой, Шар хоолой, Их ам, Бага ам, Туул ферм, Шивэртийн ам, Сүүл даваа Дархитын ам, Хуандайн ам, Арцатын ам, Дээндийн ам, Могойт дэнж, Хар усан тохой Майхан уулын зүүн энгэр		741.27	11860		
15.		21	Бага Дарь-Эх, Сэлбэ, Жамсран уулын Өвөр болон Ар, Ганц худгийн ам, Богдын даваа, Тоосгоны үйлдвэрийн орчим		4.7	94		
16.		21	Ганцын худгийн задгай /Хорих ангийн хамгаалалтын бүсэд орсон айл/		43.0	850		
17.		22	Баруун алтан өлгий, Зүүн алтан өлгий, Бунханы		2.7	60		
18.		23	Улиастайн хэсэг, Баатархайрханы хэсэг, Сургуулийн хэсэг		26.78	447		
19.		24	Цахлай, Овоот Жаргалант, Хоршооллын гудамж, Газарчин		4.3	87		
20.		27	Дунд дарь-эх, Сэлбэ		2.4	40		
21.		28	Хужирбулан 1, 2, 3, 4, 5 дугаар хэсэг		5.3	83		
<b>Нийт</b>					<b>924.05</b>	<b>15156</b>		

2.2. Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ								
д/д	Дүүрэг	Хороо	Газрын байршил	Иргэдийн тоо	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага

0	1	2	3	4	5	6	7	8
1.	Баянзүрх	2	Их, Бага, Дунд Дарь-Эхийн гудамж	14	0.52	Гэр бүлийн хэрэгцээнд	I-IV улиралд	НГЗБА, ДГЗБА
2.		4	Цэргийн хотхоны Наран, Карьер, Сайханы, Сансар хотхон, Нарангийн гудамж	70	2.9			
3.		5	Алтан-Өлгийн, Монелын гудамж	100	5			
4.		8	Улаанхуаран, Эрдэнэтолгойн, Холбоотолгойн гудамж	19	0.8			
5.		9	Шархад, Ээж хайрханы гудамж	140	8.4			
6.		10	Хангамж, Улаанхуаран, Витсамо, Төмөр замын, Сургуулийн, Улиастайн, Баатархайрханы гудамж	45	2.4			
7.		11	Товчоо, Дэнж, Туул, Замчин, Усан сан, Ногоон зоорь, Баянбулаг, Баянзүрх, Хонхор, Булгачин, Сургууль, Хөх тэнгэр хотхон, Ганц мод, Хонхор нуурын гудамж	200	12.75			
8.		12	Чулуун-Овоо АОС, Сармисны хонхор, Төмөр замын гудамж, Жанжины буйрын зүүн урд хэсэг	11	0.48			
9.		13	Дүүрэг, Алтан тэвшийн АОС	5	0.22			
10.		14	Консулын гудамж	2	0.06			
11.		16	Цэргийн их сургуулийн гудамж	3	0.18			
12.		17	Эмнэлэг, Холбоотолгойн гудамж	18	0.9			
13.		19	Цайз, Жаргалант, Хоршоолол Дэнжийн гудамж	55	2.75			
14.		20	Туулын Төвийн хэсэг, Баяндөхөм, Гялалзахын энгэр, Шар хоолойн хадтай, 10 айл орчим	150	9.5			
15.		21	Сэлбэ, Жамсран уулын ар, өвөрийн хэсэг, Бага Дарь-Эх, Тоосгоны хэсэг, Ганц худаг орчмын шинэ суурьшил	115	5.47			
16.		22	Баруун Алтан-Өлгий, Зүүн Алтан-Өлгий, Бунханы гудамж	50	2.55			
17.		23	Баатархайрхан, Сургууль, Улиастайн хэсэг гудамж	85	5.1			
18.		24	Цахлай, Овоот, Хоршоолол, Газарчин, Эрдэнэтолгой, Жаргалантын гудамж	50	2.5			
19.		27	Дунд Дарь Эх, Сэлбийн, Суврагын баруун урд гудамж	20	1			
20.		28	Хужирбулангийн гудамж	85	5.1			
<b>Нийт</b>				<b>1237</b>	<b>68.58</b>			

**2.3. Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд**

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо	Цагаан даваа	Авто гарааш	0.05	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур	Бичил цэцэрлэгт хүрээлэн	2.0	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	11 дүгээр хороо	Худаг	0.01	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
4.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Арцат ам	Цэцэрлэгт хүрээлэн	2.0	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
5.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Их хуандай ам	Ахмад настны сувилал	2.0	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
6.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Арцат ам	Хүүхдийн нөхөн сэргээх төв	2.0	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
7.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Худаг 4	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
8.	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо	Бага дарь-эх /Ганцын задгай/	Ажилчдын байр	0.25	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ

9.	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Худаг	0.01	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
10.	Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Худаг	0.01	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
11.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Авто завсар	0.30	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
12.	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо	22 дугаар цэцэрлэгийн хойд талд	Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд	0.07	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
13.	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо	22 дугаар цэцэрлэгийн хойд талд		0.20	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
14.	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо	30 дугаар сургуулийн баруун талд		0.20	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
15.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор		54.0	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
16.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур		2.00	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
17.	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо	Алтан өргөө хотхоны зүүн талд		0.13	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
18.	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо	Хос өргөө СӨХ-ын баруун талд		0.06	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
19.	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо	122-р цэцэрлэгийн баруун хойно		0.05	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
20.	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	72-р хотхон 2-р байрны хойд талд		0.12	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
21.	Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо	147-р цэцэрлэгийн баруун талд		0.18	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
22.	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо	38 байрны урд талд		Цэцэрлэг	0.27	III-IV улиралд
23.	Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо	Хорооны байрны баруун болон зүүн талд	ӨЭМТ	0.14	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
24.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	Тоосгоны ар	Худаг	0.01	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
25.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор	Дотуур байр	0.2	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
26.	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо	Хорооны байрны хажууд	Цэцэрлэг	0.05	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
27.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Дээндий ам	Спортын талбай	3.0	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
28.	Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо	Улиастай	Мод үржүүлэг	60.0	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
29.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	Цахлайн 14 дүгээр гудамж	Хүүхдийн тоглоомын талбай	0.18	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
<b>Нийт</b>				<b>129.53</b>		

**2.4 Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын зориулалт, байршил, хэмжээ**

д/д	Дүүрэг, хороо	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Баянзүрх хайрхан, Хонхор нуур, Сүүл даваа, Дунд даваа /15 байршил/	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ, Үйлдвэрлэл, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, Цэцэрлэгт хүрээлэн,	70.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ

2.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Гачуурт, Улиастайн ам, Шар хоолойн ам, Арцат, Хуандай ам, Дээндий ам /30 байршил/	Тохижилт ногоон байгууламж, Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, Газар тариалан	456.3	II-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Баянзүрх уул /5 байршил/	Мод үржүүлэг	10.0	II-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
4.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Их Хуандай ам /5 байршил/	Мод үржүүлэг	10	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
5.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Их Хуандай ам /5 байршил/	Мод үржүүлэг	10	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
6.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Улиастай ам /8 байршил/	Мод үржүүлэг, төмс хүнсний ногоо	20	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
7.	Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо	Улиастай гүүрний зүүн урд талд	Сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар	5.0	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
8.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор нуур,	Мод үржүүлэг	4.0	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
9.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Дээндий ам	Интернэт сүлжээ дамжуулах станц	0.01	III-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
<b>Нийт</b>				<b>585.41</b>		

<b>2.5 Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох</b>						
<b>д/д</b>	<b>Дүүрэг, хороо</b>	<b>Газрын байршил</b>	<b>Зориулалт</b>	<b>Газрын хэмжээ /га/</b>	<b>Хугацаа</b>	<b>Хариуцах байгууллага</b>
1.	Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо	33-р сургуулийн баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.05	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо	33-р сургуулийн зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.10	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо	Жуковын гудамж 2-р байр хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
4.	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо	Кино үйлдвэрийн баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.11	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
5.	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо	97-р сургуулийн зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
6.	Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо	Цагдаагийн гудамж-Троллейбусны эцсийн буудал	Тохижилт, ногоон байгууламж	0.006	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
7.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	Ээж хайрхан 8 дугаар гудамж	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
8.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	Шархад 45 дугаар гудамж	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
9.	Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо	10 дугаар хорооны байрны баруун урд орон сууцны хороолол дунд	Тохижилт, ногоон байгууламж	0.02	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
10.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Хонхор, Төмөр замын тойрог	Тохижилт, ногоон байгууламж	9.5	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
11.	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо	13-р хорооллын Автобусны буудлын урд талд 6-р байрны хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.13	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
12.	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо	4-р байрны урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.05	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ

13.	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	1, 2 дугаар байрны орчимд	Тохижилт, ногоон байгууламж	0.003	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
14.	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	72-р хотхон гудамж, 44-р сургуулийн зүүн талд 27 дугаар байрны баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.06	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
15.	Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо	Холбоо толгойн 40-р гудамж	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
16.	Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо	84 дүгээр сургуулийн зүүн талд, 756 байрны зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
17.	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо	24-р хорооны байрны баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.05	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
18.	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо	Үндсэн хүнс ХХК-ний урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.19	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
19.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Монгол шилтгээн цогцолборын хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
20.	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо	202-р цэцэрлэгийн урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
21.	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо	127-р сургуулийн урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
22.	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо	Зүүн Алтан-Өлгий 12 дугаар хэсэгт	Тохижилт, ногоон байгууламж	0.035	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
23.	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо	155 дугаар сургуулийн урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.3	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
24.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	Цахлайн 8-13а тоот хашааны урд	Тохижилт, ногоон байгууламж	0.09	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
25.	Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо	Баатархайрхан 26 хэсэг	Тохижилт, ногоон байгууламж	13.43	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
26.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	Жаргалантын 4-29 тоот хашааны ард	Тохижилт, ногоон байгууламж	0.09	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
<b>Нийт</b>				<b>24.8</b>		

**2.6 Авто зам, замын байгууламж**

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Талбай /мв/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо	2-р хэсэг Их-Отгор дэлгүүрээс хойш жалга дагуу 3-р хэсэг 495 дугаар худаг хүртэлх	1.08	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо	Хас март дэлгүүрээс 2 дугаар хорооны цогцолбор байр хүртэлх	0.26	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	МТ шатахуун түгээх станцаас хойш Дотоодын цэргийн 805 дугаар ангийн зүүн тал хүртэлх	0.55	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
4.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Нарангийн 9 дүгээр гудамжны урд үзүүрээс зайсан-2 хүртэлх	0.60	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
5.	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо	Кино үйлдвэрийн авто замаас Баянзүрх эмнэлгийн баруун тал хүртлэх	0.26	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
6.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замаас 126 дугаар сургууль хүртэлх	0.25	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ

7.	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо	Да-Хүрээгийн гудамжнаас Тамирчны гудамж хүртэлх	0.92	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
8.	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо	Газарчингийн 7-12 тоотоос Газарчингийн 7-20 тоот хүртэлх	0.2	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
9.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Гачууртын авто замаас 63 дугаар цэцэрлэг хүртэлх	0.15	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
10.	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо	22 дугаар хорооны хойд гудамжаар зүүн тийшээ цайзын зам хүртэлх	0.55	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
11.	Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо	Сургуулийн 4-р хэсэг 1908 тоотоос 4а-1624 тоот хүртэлх	1.5	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
12.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	Хоршооллын 1-1 тоот, Хоршооллын 2-1 тоот, Хоршооллын 5-1 тоот, Хоршооллын 4-12 тоот хүртэлх	0.9	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
13.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	Цахлайн 2 дугаар гудамжнаас Цахлайн 15 дугаар гудамж хүртэлх	0.29	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
14.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	Хоршоолол 14 дүгээр гудамжнаас Цахлайн 2 дугаар гудамж хүртэлх	0.51	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
15.	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо	Шинэ Монгол сургуулийн баруун талын авто замаас баруун тийшээ	0.1	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
16.	Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо	157 дугаар сургуулийн зүүн талаар Дүнжингарав болон Нарны замын нүхэн гарцтай холбогдох	0.3	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
17.	Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо	Гачууртын авто замаас 4 дүгээр хэсэг	0.2	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
18.	Баянзүрх дүүргийн 2, 5, 19, 21, 22, 24, 27 дугаар хороо	Баянзүрх дүүргийн 2, 5, 19, 21, 22, 24, 27 дугаар хороодыг холбосон	7.21	Авто зам	I-IV улиралд	НАЗГ, НГЗБА, БЗДГЗБА, ДЗДТГ
19.	Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо	Улаанхуарангийн гудамжнаас 68 дугаар сургуулийн баруун талаар Цагдаагийн академийн өргөн чөлөөтэй холбох	0.29	Авто зам	I-IV улиралд	НГЗБА, НАЗХГ, БЗДГЗБА
20.	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо	Ахмадын хорооллын зүүн талаарх далан дагасан гудамж, зам	0.27	Авто зам	I-IV улиралд	НГЗБА, НАЗХГ, БЗДГЗБА
21.	Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо	132 дугаар сургууль, цэцэрлэгийн цогцолбороос ганц худгийн авто замтай холбох	1.4	Авто зам	I-IV улиралд	НГЗБА, НАЗХГ, БЗДГЗБА
<b>Нийт</b>			<b>17.79</b>			

**2.7 Орчны тохижилт, ногоон байгууламж, явган хүний замыг нэмэгдүүлэх**

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо	1 дүгээр хороо	Явган зам талбайн тохижилтын ажил	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо	Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо	Тохижилт, ногоон байгууламж	0.21	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо	1, 2 дугаар байрны хойно	Тохижилт, ногоон байгууламж	0.09	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
4.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Сайхан худгийн баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ

5.	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо	204-205 дугаар байрны дунд	Тохижилт, ногоон байгууламж	0.09	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
6.	Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо	60 дугаар байрны	Тохижилт, ногоон байгууламж	0.06	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
7.	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо,	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
8.	Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо	Тэнүүн хотхон	авто зам, засвар тохижилтын ажил	0.07	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
9.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	13 дугаар гудамж "Бидний гудамж" төсөл	Тохижилт, ногоон байгууламж	0.41	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
10.	Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо	Цагдаа хотхон	Тохижилт, ногоон байгууламж	0.15	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
11.	Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо	Жанжны 16 гудамж	Тохижилт, ногоон байгууламж	0.19	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
12.	Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо	127 дугаар байрны орчим	Тохижилт, ногоон байгууламж	0.18	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
13.	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо	Автобусны буудал	Тохижилт, ногоон байгууламж	0.03	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
14.	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо	5 дугаар байрны баруун талд	Авто зогсоолын тохижилтын ажил	0.09	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
15.	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	10 дугаар байрны урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.29	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
16.	Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо	Эмнэлгийн 27 дугаар гудамж	Тохижилт, ногоон байгууламж	0.19	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
17.	Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо	12 дугаар байрны баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.05	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
18.	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо	19 дүгээр хороо	гүүрэн гарцын тохижилтын ажил	0.01	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
19.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Туул голын баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.61	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
20.	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо	155 дугаар сургуулийн гадна	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
21.	Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо	Ид шидийн орны хойд талд 3*3 сагсан бөмбөгийн талбайн	Тохижилт, ногоон байгууламж	0.03	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
22.	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо	3*3 сагсан бөмбөгийн талбайн	Тохижилт, ногоон байгууламж	0.10	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
23.	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо	166, 167 дугаар байрны дунд	Тохижилт, ногоон байгууламж	0.06	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
24.	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо	Хаан, хатан хотхоны	Тохижилт, ногоон байгууламж	0.09	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
25.	Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо	15 дугаар хэсэгт 3*3 сагсан бөмбөгийн талбай	Тохижилт, ногоон байгууламж	0.02	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
26.	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо	Сансарын тунель, хорооны байрны зүүн хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.12	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
27.	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо	Сансарын тунель, 26 дугаар байрны зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.06	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ

28.	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо	Сансарын тунель, 28 дугаар байрны баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.05	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
29.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	191 дүгээр цэцэрлэг болон 112, 114 дүгээр байрны баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.21	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
30.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	110 дугаар байрны урд, эрүүл мэндийн 10 дугаар төвийн баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.14	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
31.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Орос 14 дүгээр сургуулийн хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.11	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
32.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	Жуковын талбайн баруун талд /21 ш тоосгон гарааш, 19ш контейнэр/	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
33.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	97 дугаар сургуулийн, 113 дугаар байрны урд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
34.	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо	97 дугаар сургуулийн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.08	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
35.	Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо	18 дугаар байрны хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.035	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
36.	Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо	22а байрны баруун талд	Тохижилт, ногоон байгууламж	0.035	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
37.	Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо	116 дугаар байрны зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.18	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
38.	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	Дандарын гудамж, 72 дугаар хотхон 1, 2, 3 дугаар байрны хойд талд	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
39.	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо	Дандарын гудамж, 44 дугаар сургуулийн зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.04	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
40.	Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо	84 дүгээр сургуулийн зүүн талд	Тохижилт, ногоон байгууламж	0.12	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
41.	Баянзүрх дүүргийн 18, 25 дугаар хороо	111 дүгээр сургуулийн зүүн хойд хэсэгт	Тохижилт, ногоон байгууламж	0.21	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
42.	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо	155 дугаар сургуулийн урд хэсэгт	Тохижилт, ногоон байгууламж	0.3	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
43.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Арцат аманд	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
44.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Шар хоолой Их аманд	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
45.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Баяндөхөм аманд	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
46.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Хар усан тохой	Тохижилт, ногоон байгууламж	0.1	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
47.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Улиастай аманд	Хүүхдийн тоглоомын талбай, амралт	2.0	I-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
<b>Дүн</b>				<b>7.56</b>		

**2.8 Газрын элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ**

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Газрын нэгдмэл сангийн ангилал	Газрын хэмжээ /га/	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
-----	---------------	----------------	--------------------------------	--------------------	--------------	---------------------	----------------------



1.	Баянзүрх дүүргийн 2, 9, 11, 20, 22, 23, 24-р хороо	Тухайн нутаг дэвсгэрт	Ойн сан бүхий газар, Усан сан бүхий газар, Хот тосгон бусад суурины газар	10 га	Мод үржүүлэг	II-IV улиралд	БЗДГЗБА, ДЗДТГ
<b>Дүн</b>				<b>10.0</b>			

**ГУРАВ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

<b>3.1 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах</b>						
д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүрэг 4, 5 дугаар хороо	“Монель” олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл	Төслийн Барилгажилтын боловсруулах	ТЭЗҮ, төсөл 14.6	I-IV улиралд	НХБХГ, БЗДГЗБА, ДЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн 8, 9, 10, 17, 23 дугаар хороо	“Амгалан” дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл	Төслийн Барилгажилтын боловсруулах	ТЭЗҮ, төсөл 127.0	I-IV улиралд	НХБХГ, БЗДГЗБА, ДЗДТГ
3.	Баянзүрх дүүрэг 11 дүгээр хороо	“Ургах наран” олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл	Төслийн Барилгажилтын боловсруулах	ТЭЗҮ, төсөл 12.0	I-IV улиралд	НХБХГ, БЗДГЗБА, ДЗДТГ
4.	Баянзүрх дүүрэг 27 дугаар хороо	“Дарь-Эх” олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл	Төслийн Барилгажилтын боловсруулах	ТЭЗҮ, төсөл 10.0	I-IV улиралд	НХБХГ, БЗДГЗБА, ДЗДТГ
<b>Дүн</b>				<b>163.6</b>		

<b>3.2 Газар шинэчлэн зохион байгуулалт хийх</b>					
д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	нэгж талбар тоо	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо	Шархадны эцэс эмнэлгийн ажилчдын нийтийн байрны орчим	35	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо	Туул зэрлэгийн орчим	217	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо	Эмнэлгийн гудамж	59	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
4.	Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо	Цайз 57 дугаар гудамжны орчимд	250	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
5.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Шар хоолой фермын төвийн хэсэг	200	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
6.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Их, бага хуандай төвийн хэсэг	109	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
7.	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо	Арцатын төвийн хэсэг	100	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
8.	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо	Бага дарь-Эх, Ганцын задгай хэсэг	900	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
9.	Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо	Баатархайрхан 2 дугаар хэсэг	89	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
10.	Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо	Хужирбулан 5 хэсэг	89	I-IV улиралд	НГЗБА, БЗДГЗБА, БЗДЗДТГ
<b>ДҮН</b>			<b>2048</b>		

**4.1 Барилга байгууламжийн газрыг чөлөөлөх**

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбарын тоо	Чөлөөлөх газрын хэмжээ /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	-	1.6	Гэрч хохирогчийг түр саатуулах зогсоол	I-IV улиралд	НГЗБА, БЗДЗДТГ
<b>Дүн</b>			<b>0</b>	<b>1.6</b>			

**4.2 Дэд төвүүдийн газрыг чөлөөлөх**

№	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбар тоо	Чөлөөлөх газрын хэмжээ /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүргийн 8, 9, 10, 17 19, 24 дүгээр хороо	Шар хад дэд төв	1	56.1	Авто зам, шугам сүлжээ	I-IV улиралд	НГЗБА, НХОГ, АХБ, БЗДГЗБА
<b>Нийт</b>			<b>1</b>	<b>56.1</b>			

**4.3 Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх**

№	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбар тоо	Чөлөөлөх газрын хэмжээ /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Баянзүрх дүүрэг 2, 21, 27 дугаар хороо	Дарь-Эхийн орчим	-	-	Гэр хорооллын ариутгах татуургын төвлөрсөн шугамын холболт	I-IV улиралд	НХОГ НГЗБА, БЗДГЗБА
2.	Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо	Төмөр замын 2 дугаар анги орчим	-	-	Дулааны шугам	I-IV улиралд	НГЗБА, НХОГ, БЗДГЗБА
3.	Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо	Ботаник орчим	16	1.5	110 кВ дэд станц	I-IV улиралд	НГЗБА, ЦДҮС, БЗДГЗБА
4.	Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо	Орон сууцны XIV хороолол орчмын хэсэгчилсэн талбайн гадна	-	1.7	Цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил	I-IV улиралд	НХОГ, НГЗБА, БЗДГЗБА
5.	Баянзүрх дүүргийн 21, 27 дугаар хороо	Хороодын нутаг дэвсгэрт	12	1.8	Үерийн хамгаалалтын барилга байгууламж	I-IV улиралд	НХОГ НГЗБА, БЗДГЗБА
<b>Нийт</b>			<b>28</b>	<b>25.0</b>			